



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 09 сарын 13 өдөр

Дугаар А/53

Улаанбаатар хот

Ажлын хэсгийн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 02/10 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/155 дугаар захирамжаар батлагдсан Газрын дүрмийн 7.1.1 дэхь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1.Эзэн богд Чингис хааны мэндэлсэн өдөр буюу Монгол бахархлын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх, түүх соёлынхоо уламжлалыг дэлхий дахинд сурталчлан таниулах, жуулчдыг татах шинэ бүтээгдэхүүн бий болгох, аялал жуулчлалын улирлын хугацааг уртасгах зорилгоор “Чингис хааны төрсөн өдөр” хаадын чуулбар арга хэмжээг билгийн тооллын өвлийн тэргүүн сарын шинийн нэгэн буюу 2022 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр жанжин Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулсугай.


2.Энэ тушаалын 1 дүгээр зүйлд заасан арга хэмжээг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор баталсугай.

3.Арга хэмжээ зохион байгуулах ажлын төлөвлөгөөг батлуулж, нэгдсэн удирдлагаар хангаж, ажлын үр дүнг танилцуулахыг Ажлын хэсэг /В.Батчимэг/-т даалгасугай.

ДАРГА *D. Batm* Д.БАТСҮХ



Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2022 оны 09 дугаар сарын 14 өдрийн
153 дугаар тушаалын хавсралт



“ЧИНГИС ХААНЫ МЭНДЭЛСЭН ӨДӨР” ХААДЫН ЧУУЛБАР АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН
БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн
ахлагч:

В.Батчимэг

Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга

Гишүүд:

С.Туул

Маркетинг сурталчилгаа хариуцсан ахлах
мэргэжилтэн

Н.Алтанзаяа

Хөгжлийн бодлого төлөвлөлт, төсөл хөтөлбөр
хариуцсан мэргэжилтэн

Т.Туул

Гадаад хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн

Б.Цолмонгэрэл

Хэвлэл мэдээлэл, олон нийт хариуцсан мэргэжилтэн

М.Мөнхцацрал

Мэдээллийн технологи, цахим хөгжил хариуцсан
ажилтан

Э.Очир-Эрдэнэ

Жуулчны мэдээллийн төвүүд хариуцсан менежер

Т.Батдорж

“Сити тур” төслийн менежер

Нарийн бичгийн
дарга:

Б.Халиун

Эвент хариуцсан мэргэжилтэн